

Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 9 тоот Хавсралт 4

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНКНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү Журмаар тогтоосон мэдээ, тайланг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт, цаг хугацаанд нь Хороо, Хөрөнгийн бирж, хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүргэх, тэдгээр мэдээ, мэдээлэл, тайлангийн төрөл, хэлбэр, давтамж болон эдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Журам нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс¹, Үнэт цаасны бүртгэлийн журам², Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам³, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам⁴ болон холбогдох бусад хууль тогтоомжийн акт, Банкны заавар, журамд нийцсэн байна.
- 1.3. Банк нь энэхүү Журмын дагуу нийтэд мэдээлбэл зохих эерэг ба сөрөг мэдээллийг хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүргэхдээ хууль дээдлэх, мэдээлэл нээлттэй, ил тод, тэнцвэртэй, бодитой, үнэн зөв, бүрэн гүйцэт, хоёрдмол утга агуулаагүй байх, мэдээллийг нийтэд хүргэх ажиллагаа шуурхай байх зарчмыг баримтална.
- 1.4. Банк аливаа мэдээллийг түгээхдээ Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хориглох зүйлс, Зар сурталчилгааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан үнэт цаасны бүртгэлийн журмуудад заасан шаардлага, хязгаарлалтуудыг удирдлага болгон ажиллана.
- 1.5. Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.5.1. “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт тус тус заасан этгээдийг;
 - 1.5.2. “Дотоод мэдээлэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт тус тус заасан мэдээллийг;
 - 1.5.3. “Мэдээллийг нээлттэй болгох” гэж Банк нь холбогдох хууль тогтоомж болон энэ Журамд заасан мэдээллийг өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Монголбанк болон Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэхийг;
 - 1.5.4. “Тухай бүр мэдээлэх” гэж энэ Журамд заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг тухайн үйл явдал болсон даруй зохих журмын дагуу нийтэд мэдээлэхийг;
 - 1.5.5. “Хороо” гэж Санхүүгийн зохицуулах хороог;
 - 1.5.6. “Хөрөнгийн бирж” гэж Монголын Хөрөнгийн Биржийг;

¹ Хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан.

² Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан.

³ Хөрөнгийн биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны 08 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан.

⁴ Хорооны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 72 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан.

- 1.5.7. “Хугацаат тайлан” гэж Банкнаас холбогдох хууль тогтоомж болон энэхүү Журамд заасан өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн агуулсан, тодорхой хугацаанд тайлагнах мэдээллийг;
- 1.5.8. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэг болон Банкны дүрэмд заасан этгээдийг;
- 1.5.9. “Үнэт цаас хариуцсан ажилтан” гэж Журмын 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн дэргэдэх Ажлын Алба (“ТУЗДАА”)-наас томилогдсон ажилтныг.

Хоёр. Мэдээлэл, түүний ангилал

- 2.1. Банкны мэдээлэл, тайлан нь хугацаат тайлан болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл гэсэн хоёр төрөлтэй байна.
- 2.2. Банкны хугацаат тайланд хагас жил, жилийн үйл ажиллагааны тайлан болон улирал, хагас жил, жилийн эцсийн санхүүгийн тайлан тус тус хамаарна.
- 2.3. Банкны жилийн үйл ажиллагааны тайлан нь Хорооны Компанийн засаглалын кодекс⁵, Үнэт цаасны бүртгэлийн журам⁶, Хөрөнгийн биржийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмаар⁷ тус тус баталсан агуулга бүхий мэдээллүүдээс бүрдэнэ.
- 2.4. Банкны хагас жилийн тайлан мэдээлэлд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай Банкны санхүү, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн шинжтэй Компанийн засаглалын кодекс, Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр хавсралтын 3 дугаар зүйл болон Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмын 7 дугаар зүйлд заасан мэдээлэл агуулагдана.
- 2.5. Банкнаас тухай бүр нийтэд нээлттэй мэдээлэх мэдээлэл гэдэгт хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчаас шийдвэр гаргахад шаардлагатай Банкны бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль тогтоомж, Компанийн засаглалын кодекс, Үнэт цаасны бүртгэлийн журам, Хөрөнгийн биржийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журамд заасан цогц мэдээллийг ойлгоно.
- 2.6. Банкны Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон цалин, урамшууллын талаарх мэдээллийг Банкны Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журамд заасны дагуу Банкны жилийн үйл ажиллагааны тайланд тусгах байдлаар нийтэд мэдээлнэ.
- 2.7. ТУЗДАА нь энэхүү Журмаас гадна Хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, заавартай танилцах боломжоор хөрөнгө оруулагч, оролцогч талуудыг хангах зорилгоор эдгээр баримт бичиг, тэдгээрийн нэмэлт өөрчлөлт, зарим хэсгийг түр түдгэлзүүлсэн талаарх мэдээллийг Банкны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Гурав. Мэдээлэл боловсруулах, нууцлах

- 3.1. Журмын 2 дугаар зүйлд заасан нийтэд нээлттэй хүргэх мэдээлэл, тайлагналыг Гүйцэтгэх удирдлага нь Банкны холбогдох заавар, журмын дагуу боловсруулна.
- 3.2. Банкны санхүүгийн болон хагас жил⁸, жилийн үйл ажиллагааны тайлан⁹, тухай бүр мэдээлэх мэдээ¹⁰ нь төрийн эрх бүхий байгууллагаас баталсан загвар, маягтын дагуу үйлдэгдсэн байх

⁵ 1.3, 1.4 – тайлбар 1, 2.2 – тайлбар 2, 2.3 – тайлбар 1, 2.4 – тайлбар 1, 2.5 – тайлбар 2, 4.3, 5.2 – тайлбар 4, 6.1 – тайлбар 2, 6.3, 7.2, 9.5 – тайлбар 1, Хавсралт 1-д тус тус заасан шаардлагыг харгалзана.

⁶ Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 2.2 дох хэсэг.

⁷ Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмын 7 дугаар зүйл.

бөгөөд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, олон нийтэд ойлгомжтой, тодорхой байдлаар илэрхийлэгдсэн байна.

- 3.3. Журамд заасны дагуу Банкны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх мэдээлэл, тайлагналыг Монгол хэл болон Англи хэлээр хамтад нь бэлтгэнэ.
- 3.4. Журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт зааснаас бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх мэдээлэл, тайлагналыг Монгол хэлээр бэлтгэж, хүргэх ба шаардлагатай гэж үзвэл гадаад хэлээр хүргэж болно.
- 3.5. Мэдээлэл, тайлагналын үнэн бодит байдлыг Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцах бөгөөд ТУЗ нь өөрийн харьяа нэгж болох Дотоод аудитын газрын бие даасан, хараат бус баталгаажуулалтаар хяналт хэрэгжүүлнэ.
- 3.6. Банкны эрх бүхий албан тушаалтан, ажилтан, дотоод мэдээлэл эзэмшигч нь дотоод мэдээлэлтэй холбоотойгоор дараах үүргийг хүлээнэ.
 - 3.6.1. Дотоод мэдээллийн улмаас ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас болон түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар оролцохгүй байх;
 - 3.6.2. Дотоод мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг бусдад санал болгохгүй, ятгахгүй байх;
 - 3.6.3. Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулахаас сэргийлэх, дотоод мэдээлэл олж авах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;
 - 3.6.4. Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Банкны дүрэм, заавар, журам болон бусад баримт бичгээр хүлээсэн бусад үүрэг.

Дөрөв. Мэдээллийг түгээх хэрэгсэл, хугацаа

- 4.1. Банк мэдээлэл, тайлагналыг нийтэд хүргэхдээ Монгол Улсын хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох заавар, журамд нийцүүлэн доор дурдсан аль нэг эсхүл хэд хэдэн хэлбэрээр нийтэд мэдээлнэ.
 - 4.1.1. Банкны цахим хуудсаар, Хөрөнгийн бирж болон Хорооны цахим хуудсаар дамжуулан;
 - 4.1.2. Хорооноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх;
 - 4.1.3. Тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.
- 4.2. Банк нь байнгын, идэвхтэй үйл ажиллагаатай албан ёсны цахим хуудастай байх бөгөөд цахим хуудаст хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад зориулсан цэстэй байна.
- 4.3. Журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэл, тайлагналыг Гүйцэтгэх удирдлага нь Банкны холбогдох заавар, журмын дагуу Үнэт цаас хариуцсан ажилтанд хүргүүлнэ.
- 4.4. Журмын 2 дугаар зүйлд заасан нийтэд мэдээлэх мэдээлэл, тайлагналыг Банкны цахим хуудсанд байршуулах ажлыг Үнэт цаас хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

⁸ Хагас жилийн үйл ажиллагааны тайланг Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр хавсралт дахь Маягт 2-ын дагуу бэлтгэнэ.

⁹ Жилийн үйл ажиллагааны тайланг Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр хавсралт дахь Маягт 1-ийн дагуу бэлтгэнэ.

¹⁰ Тухай бүр мэдээлэх мэдээллийг Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр хавсралт дахь Маягт 3-ын дагуу бэлтгэнэ.

- 4.5. Журмын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан мэдээлэл, тайлагналыг Гүйцэтгэх удирдлага цаасан болон цахим хэлбэрээр тухай бүр Үнэт цаас хариуцсан ажилтанд хүргүүлнэ.
- 4.6. Журамд заасан мэдээлэл, тайлагналыг Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Хөрөнгийн биржийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журамд заасан хугацаа болон хэлбэрээр нийтэд мэдээнэ.
- 4.7. Үнэт цаас хариуцсан ажилтан нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.7.1. Хөрөнгийн биржээс түүнд өгсөн цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх/нууц дугаар бүхий/-ийг ашиглан журмын 3 дугаар зүйлд заасны дагуу боловсруулсан Журмын 2 дугаар зүйлд заасан мэдээллийг хөрөнгийн биржийн цахим хуудсанд оруулах;
- 4.7.2. Банкнаас Журамд заасны дагуу мэдээлсэн мэдээлэл, тайлан болон үнэт цаасны арилжаа, бүртгэлийн мэдээлэлд алдаа, зөрүү гарсан тохиолдолд Гүйцэтгэх удирдлага болон Үнэт цаас хариуцсан ажилтан нь түүнийг нэн даруй залруулж, өөрийн цахим хуудас болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд энэ тухай мэдээлэх;
- 4.7.3. Журамд заасан тайлан, мэдээллийг нийтэд мэдээлэх, тайлагнах хугацаа, арга, суваг зэрэгт өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр Банкны цахим хуудсаар дамжуулан тайлбар хийж, нийтэд мэдээлэх;
- 4.7.4. Хууль тогтоомж, Монголбанк, Хороо, Хөрөнгийн бирж болон Банкны дүрэм, заавар, журамд заасан бусад үүрэг.
- 4.8. Үнэт цаас хариуцсан ажилтан Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.
- 4.9. Банк нь Журмын 2 дугаар зүйлд заасан мэдээлэл, тайлагналаас гадна хөрөнгө оруулагчдад шаардлагатай гэж үзсэн Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх бусад мэдээллийг нийтэд мэдээлж болно.

Тав. Хориглох зүйл

- 5.1. Журмын 2 дугаар зүйлд заасан мэдээллийг журмын дагуу нийтэд мэдээлэхээс өмнө бусдад задруулах, уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг Банкны хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан, дотоод мэдээлэл эзэмшигчдэд хориглох бөгөөд эдгээр нь мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.
- 5.2. Үнэт цаас хариуцсан ажилтан нь Журмын 4 дүгээр зүйлийн 4.7.1 дэх заалтад заасан эрхийг холбогдох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, ашиглуулах, хувийн зорилгоор ашиглах, бусдад ашиглах боломж нөхцөлийг санаатай болон санамсаргүйгээр бий болгохыг хориглоно.

Зургаа. Хариуцлага

- 6.1. Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй бол Банк хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.
- 6.2. Журмыг зөрчсөн холбогдох ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран Банк Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Банкны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.
- 6.3. Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь Банкны болон хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эд хөрөнгөнд хохирол учруулсан бол түүнд сахилгын, эрүүгийн хариуцлага, түүнчлэн Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран гэм буруутай ажилтан хариуцлага хүлээнэ.

- 6.4. Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь Банкны ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан бол уг гэм хорыг тухайн этгээд хариуцан арилгана.

Долоо. Бусад

- 7.1. ТУЗ нь Журмын хэрэгжилтэд Дотоод аудитын газраар дамжуулан хяналт тавина.
- 7.2. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗДАА хамтран Журмын хүрээнд хийгдсэн ажлын тайланг жилд нэг удаа болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн хугацаанд ТУЗ-д тайлагнана.
- 7.3. ТУЗДАА нь Журмын дагуу Хороо, Хөрөнгийн биржид хүргүүлсэн болон нийтэд хүргүүлсэн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хадгалах ба тухайн бүрдүүлсэн санг Банкны архивын үйл ажиллагаатай холбоотой заавар, журмын дагуу Банкны архивт шилжүүлнэ.